

NEAR News

Нэг Зүүн хойд Ази- Нэг хамтын нийгэмлэг NEAR | One Northeast Asia Region, One Community NEAR

2017 оны 1-2 сар

Vol. 72



Амахараши далайн эрэг(Япон улс, Тояма муж)

Шинэ оны мэндчилгээ

ЗХАНЗХ-ны Тэргүүлэгч бөгөөд БНХАУ-ын Хунан мужийн Захирагчийн мэндчилгээ
ЗХАНЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргын мэндчилгээ

Энэ сарын мэдээ

NEAR Холбооны үйл ажиллагаа | Холбооны Хэрэг эрхлэх газрын мэдээ
Гишүүн орон нутгуудын мэдээ | Гишүүн орон нутгуудад зохиогдох олон улсын арга хэмжээ(1~2 сар)

Эдийн засгийн булан

-Гёнсанбүг мужийн эдийн засаг, аж үйлдвэрийн өнөөгийн байдал
-Гёнсанбүг мужаас НҮБ-тай хамтран өрнүүлдэг Сэ Мауль хөдөлгөөн
-Пуханы гэрлэн хурдасгуурын лаборатори | Поско Ган төмөрлөгийн үйлдвэр

Тусгай нийтлэл

- NEAR 2016-Олон улсын форум
- NEAR-Хүүхэд сурагчдад зориулсан 4 дэх удаагийн эссэ бичлэгийн уралдааны тэргүүн байрын бүтээлүүдээс толилуулах нь



Зүүн Хойд Азийн Нутгийн
Захиргаадын Холбоо

The Association of Northeast Asia Regional Governments

NEAR News

NEAR News сэтгүүл нь гишүүн байгууллагуудын мэдээг дамжуулах, харилцан мэдээлэл солилцох албан ёсны хэвлэл юм. NEAR Холбооны гол үйл ажиллагаа, гишүүн орон нутгуудын мэдээ, төрөл бүрийн нийтлэл, зарлал зэргийг голчлон нийтэлдэг 2 сар тутмын хэвлэл бөгөөд гишүүн орон нутаг, холбогдох байгууллагуудад үнэгүй тараадаг. Мөн сэтгүүлийг онлайн хэлбэрээр Холбооны вэбсайтад тавьдаг.

NEAR News сэтгүүл гишүүн орон нутгийн нийтийн бүтээл бөгөөд Зүүн хойд Азийн бүсийг сонирхогч хэн бүхэнд нээлттэй.

Сэтгүүлд чанартай нийтлэл, шинэ санаа оноо тусгахыг хүсвэл бидэнд хандана уу.



Vol. 72





Зүүн хойд Азийн 6 улс(Монгол, Орос, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос)-ын 82 орон нутаг(77 гишүүн орон нутаг, 5 ажиглагч статустай орон нутаг)-аас бүрдэх Зүүн хойд Азийг төлөөлөх орон нутгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны олон улсын байгууллага юм.

Тус Холбоо хамтын хөгжил цэцэглэлт гэсэн үндсэн үзэл санаан дор Холбооны үндсэн дүрмийг баталж, эдийн засаг, хүмүүнлэгийн харилцаа, худалдаа, боловсрол соёлын харилцаа, байгаль орчин, гамшгаас сэргийлэх, хилийн хамтын ажиллагаа, шинжлэх ухаан технологи, аялал жуулчлал, далай загасны аж үйлдвэр, эрдэс баялаг, зохицуулалт, хүүхэд эмэгтэйчүүд, эмчилгээ, газар тариалан зэрэг төрөл бүрийн салбарт өргөн харилцаа, хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна. Европын орон нутгийн хамтын ажиллагааны төлөөлөх байгууллага AER(Европын Нутгийн Захиргаадын Холбоо), R20(Уур Амьсгалын Өөрчлөлтийн Эсрэг Үйл Ажиллагааны Холбоо), ICLEI(Дэлхийн Нутгийн Захиргаадын Холбоо)

зэрэг олон улсын байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоох, хамтын төсөл явуулах зэргээр идэвхтэй харилцан Зүүн хойд Ази төдийгүй дэлхийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагааг явуулахад хичээн чармайж байна

NEAR Холбооны үүд хаалга үргэлж нээлттэй байна

Зүүн хойд Азийн бүсэд байршилтай, Холбооны үндсэн үзэл санаатай санал нэг орон нутгийн захиргаад тус Холбооны Бүгд хуралд оролцож, гишүүнээр элсэн орж болно.



Зүүн хойд Азийн нутгийн захиргаадын Холбоо

The Association of Northeast Asia Regional Governments



Шяо Да Жиэ
ЗХАНЗХ-ны Тэргүүлэгч бөгөөд
Хунан мужийн Захирагч

Шинэ оны өмнө их үүрэг хариуцлагатай ажлыг хүлээн авсан Хунан мужийн Ардын засаг болон мужийн 73 сая иргэдийг төлөөлөн Зүүн хойд Азийн бүсийн нийт иргэдэд мэнд дэвшүүлье.

ЗХАНЗХ(NEAR) 1996 онд байгуулагдсанаас хойш гишүүн орон нутаг хооронд эдийн засаг, соёл, зэрэг салбарын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, улс хоорондын нөхөрлөлийн харилцаа, хамтын хөгжлийг эрчимжүүлэхэд чухал үүрэг хариуцлага хүлээн Зүүн хойд Азийн бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулсан билээ. Эдийн засгийн салбар даяаршиж буйг дагаад Зүүн хойд Азийн бүс одоо дэлхийн эдийн засгийн гуравдагч хөшүүрэг болсон. Миний бие гишүүн орон нутаг хооронд харилцаа, хамтын ажиллагааг улам нэмэгдүүлж, Зүүн хойд Азийн бүсийн харилцаанд гүүрийн үүрэг гүйцэтгэх болно гэдэгт бат итгэлтэй байна.

Шинэ Хятадыг үүсгэн байгуулагч Мао Зэ Дуны төрсөн нутаг Хунан муж Хятадын төв хэсэгт орших бөгөөд 21.180.000км² газар нутагтай, 14 хот, 122 хотын энтэй дүүргээс бүрдэх ба 73 сая хүн амтай. Өнө эртний түүх, уламжлалт соёлоороо бахархдаг Хунан мужид зам тээвэр сайн хөгжсөн эд бараа элбэг дэлбэг, шинжлэх ухаан, технологи, боловсролын салбар нь түлхүү хөгжсөн.

Эртнээс загас, будаа, металл, металл бишийн нөөц ихтэй, аялал жуулчлалын газар гэгдэж ирсэн. Мөн машин техник үйлдвэрлэл, төмөр зам, электрон мэдээлэл, шинэлэг материал, нефть хими үйлдвэрлэл, автомашин, сэлбэг, хатуу хайлш зэрэг аж үйлдвэрийн салбарт манлайлдаг.

Одоо Хунан муж “Нэг бүс-нэг зам” бодлогын үйл ажиллагаанд оролцож байна. Хамтын хүчээр шинэчлэлийг манлайлж, шинэчлэл нээлттэй байдлын стратегиар дамжуулан зам тээврийн нэгдсэн төвийг байгуулан шинжлэх ухаан соёлын шинэчлэл, шинэ хот, хөдөөгийн 4 тогтолцоог байгуулах болон орчин үеийн үйлдвэрлэл, соёлын бүтээлч байдал, газар тариалангийн шилдэг бүтээгдэхүүнийг гаргах, аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх, шинжлэх ухаан технологи гэсэн 5 чиглэлийн шинэчлэл, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, экологийн чиглэлээр манлайлж үзэсгэлэнтэй, аз жаргалтай Хунан мужийг бий болгохыг эрмэлзэж байна. Хунан муж цаашид Холбооны тэргүүлэгчийн хувьд Холбоогоор дамжуулан дотоод, гадаадын зах зээл, нөөц баялагийг ашиглан үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөн гишүүн орон нутаг хоорондын харилцаа хамтын ажиллагааг улам идэвхжүүлэх болно. Бид гишүүн орон нутаг болон дэлхийн бусад улс орнууд Хунан мужтай харилцах, хамтдаа хөгжихийг чин сэтгэлээс хүсч байна.

Зүүн хойд Азийн нийт ард түмэнд эрүүл энх, гэр бүлд нь аз жаргалыг хүсэн ерөөе.



Жон Жэ Вон
ЗХАНЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн
дарга

2017 онд ЗХАНЗХ-ны гишүүн орон нутгуудын нийт ард иргэдэд юу санасан хүсэл нь сэтгэлчлэн бүтэхийн өлзийтэй ерөөлийг дэвшүүлье.

Өнгөрсөн жил Гамшгаас сэргийлэх, Боловсрол соёл, Хилийн хамтын ажиллагаа гэсэн 3 салбар хороо, Залуу удирдагч форум, Хүүхэд сурагчдад зориулсан эссэ бичлэгийн уралдаан, NEAR Олон улсын форум, Холбооны 11-р Бүтд хурлыг зохион байгуулж гишүүн орон нутаг хооронд бодит харилцааг явуулахад хичээсэн билээ.

ЗХАНЗХ 1996 онд байгуулагдсанаас хойш хамгийн сүүлд ОХУ-ын Эрхүү мужид Холбооны 11-р Бүтд хурлыг зохион байгуулсан. Хурлын үеэр Холбоонд гишүүн нэмж элссэнээр өдгөө 77 гишүүн орон нутгийн 660 сая хүн амыг хамрах Зүүн хойд Азийг төлөөлөх орон нутгийн захиргааны хамтын ажиллагааны байгууллага болсон юм.

Мөн Холбооны хөгжил, гишүүн орон нутгуудын нийтлэг зорилгод нийцэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд гишүүний татвар төлөх журмыг 2018 оноос эхлэн мөрдүүлжээр болсон. Түүнчлэн сурвалжлагч гишүүний тогтолцоог шинээр гарган Зүүн хойд Азиас гадна Азийн бусад бүсийн орон нутгуудыг ч Холбооны үйл ажиллагаанд оролцуулан гишүүн орон нутгууд харилцах боломжийг бүрдүүлсэн билээ.

Мөн Европын Орон Нутгийн Захиргааны Холбоо(AER), Уур Амьсгалын Өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааны Дэлхийн Орон Нутгийн Захиргааны Байгууллага(R20), Тогтвортой Хөгжлийн төлөөх Дэлхийн Орон Нутгийн Захиргааны Байгууллага(ICLEI) зэрэг олон улсын байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоон ажиллаж байна.

Өнөө үед Зүүн хойд Азийн бүс нь эдийн засаг, улс төр, нийгэм соёлын олон салбарт дэлхийн анхаарлын төвд буйн хувьд олон янзын сорилт, боломж хослон байдаг онцлогтой бүс юм. Тус Холбооны Хэрэг эрхлэх газар нь харилцан ашигтай, эрх тэгш зарчимд үндэслэн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн итгэлцлийг бэхжүүлэн улмаар Зүүн хойд Азийн энх тайван хамтын хөгжил дэвшилд хүрэх орчин нөхцлийг бүрдүүлэх юм.

ЗХАНЗХ(NEAR)-ны давуу тал гэж хэлж болох салбар хороодын үйл ажиллагаагаар дамжуулан бодит хамтын ажиллагааг явуулахын тулд салбарын холбогдох төрийн албан хаагчдаас гадна иргэд, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулж байна. Иймд гишүүн орон нутгуудын зүгээс бидний үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж анхаарна гэдэгт найдаж байна.

Цаашид тус Холбооны Хэрэг эрхлэх газар Холбооны тэргүүлэгч болох БНХАУ-ын Хунан мужтай нягт хамтын харилцаатай байхын зэрэгцээ шинэ онд зохион байгуулах Холбооны Ажлын хэсгийн хорооны хурлаас авахуулаад олон талын харилцаа хамтын ажиллагааны үйл ажиллагааг өрнүүлэхэд дээд зэргээр анхаарах болно. Гишүүн орон нутгуудын зүгээс Холбооны үйл ажиллагаанд өргөнөөр оролцож, үнэтэй санал бодлоосоо хуваалцахад бид баяртай байх болно.

Төгсгөлд нь 2017 онд та бүхэнд болон гэр бүлд тань эрүүл энх, аз жаргалыг хүсэн ерөөе.

Шинэ оны мэнд дэвшүүлье.

ЗХАНЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга

Жон Жэ Вон

NEAR Холбооны үйл ажиллагаа

NEAR 2016-Олон улсын форум болж өнгөрлөө.



11 дүгээр сарын 25-ны өдрөөс 26-ны өдрийг хүртэл БНСУ-ын Гёнсанбүт мужийн Андон хотноо NEAR 2016-Олон улсын форум болж өнгөрлөө. “Зүүн хойд Азийн бүсийн аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа, хөгжил” хэмээх сэдвээр болсон энэхүү форумд гишүүн орон нутгуудын төрийн албан хаагч, холбогдох байгууллагын төлөөлөл зэрэг 300 гаруй хүн оролцлоо.

Аялал жуулчлал ба орон нутгийн хөгжил, тогтвортой аялал жуулчлал ба олон улсын хамтын ажиллагаа, Зүүн хойд Азийн аялал жуулчлалын хамтын ажиллагаа хэмээх дагалдах сэдвүүдээр илтгэл тавьж хэлэлцүүлэг өрнүүлэв.

Мөн форумын үеэр улс бүрээр аялал жуулчлалыг сурталчлах павилион

ажиллуулж гишүүн орон нутгуудын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах боломжийг олгов.

Дэлгэрэнгүй агуулгыг тусгай нийтлэл булангаас үзнэ үү.

Холбооны Гамшгаас сэргийлэх хорооны хурал 3 дугаар сард болно.

3 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд Япон улсын Хёго мужид Гамшгаас сэргийлэх хорооны хурал болно. Гамшгаас сэргийлэх хорооноос гишүүн орон нутгуудын гамшиг, онцгой байдлын чиглэлийн үйл ажиллагааг бэхжүүлэх, Зүүн хойд Азийн гамшигийн хохирлыг багасгах зорилгоор 2002 оноос эхлэн жил бүр хурал арга хэмжээ зохион байгуулж байна.

Хурлыг зохион байгуулах Хёго мужийн хувьд 1995 онд мужийн Кобэ хот болон Ханшин Аважи нутагт болсон хүчтэй газар хөдлөлтөөс үүдэлтэй туршлага сургамжид үндэслэн төрөл бүрийн гамшиг онцгой байдлын чиглэлийн бодлого арга замыг боловсруулахаас гадна гамшиг онцгой байдлын чиглэлийн байгууламжийг барихад ч анхаарч ирсэн. Хурлын хугацаанд гамшгаас сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагын төлөөлөл илтгэл тавих болон салбарын мэргэжилтнүүд хооронд санал бодол солилцох хэлэлцүүлэг өрнүүлэхээс гадна Хёго мужийн гамшигийн чиглэлийн холбогдох байгууллагуудаар газар дээр нь очин танилцан туршлага судалдаг.

Холбооны Хэрэг эрхлэх газрын мэдээ

ЗХАНЗХ-ны Хэрэг эрхлэх газрын хамт олон аялалаар явав.

10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд ЗХАНЗХ(NEAR)-ны ХЭГ-ын хамт олон Ганвон мужийн Янгү, Сугчу гэх мэт Зүүн тэнгисийн эрэг дагуу газраар аялахын зэрэгцээ хамт олны чөлөөт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Тухайлбал байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх арга замын талаар чөлөөтэй хэлэлцэж, санал бодлоо хуваалцав. Мөн Хойд Өмнөд Солонгосын цэргийн зэвсэггүй бүсийн дэргэдэх Үльжи алсыг харах оргил, Эв нэгдлийн бэлгэдлийн музей зэргийг үзэж сонирхон Солонгосын хойгийн нөхцөл байдлын талаар ойлголтоо нэмэгдүүлэхээс гадна Сорагсан уул, Нагсанса Буддын сүмыг үзэж сонирхов. Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон “Энэ удаагийн хамт олны хэлэлцүүлгээр авуштай санаа олон гарсан бөгөөд цаашид үйл ажиллагаандаа тусгах болно” гэж онцлон хэлэв.



Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон Зүүн хойд Азийн судалгааны сан байгуулагдсаны 9 жилийн ойн баярын арга хэмжээнд оролцов.



11 дүгээр сарын 3-ны өдөр Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон Сөүл хотноо болсон Зүүн хойд Азийн судалгааны сан байгуулагдсаны 9 жилийн ойн арга хэмжээнд оролцов. Зүүн хойд Азийн судалгааны сангаас зохион байгуулж БНСУ-ын Эв нэгдлийн яам, Солонгосын хойгийг хөгжүүлэх сангаас ивээн тэтгэсэн энэхүү арга хэмжээний хүрээнд “Зүүн хойд Азийн улс төрийн байдлын өөрчлөлт ба Солонгосын дипломат харилцааны чиг хандлага” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурал болж өндөрлөлөө. Дараагаар нь “Зүүн хойд Азийн олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулсан байгууллагад шагнал гардуулах”, “Эв нэгдлийн тухай зохион бичлэгийн уралдааны шагнал гардуулах” ёслолын ажиллагаа тус тус болж өнгөрөв. Нөгөөтэйгүүр ЗХАНЗХ нь 2015 онд Зүүн хойд Азийн орон нутгуудын дипломат харилцаанд гол үүрэг гүйцэтгэж ирсний хувьд “Зүүн хойд Азийн олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулсан байгууллага”-аар шалгарч шагнуулж байсан удаатай билээ.

Ерөнхий нарийн бичгийн дарга "Глобал хотуудын форум"-д оролцов.

11 дүгээр сарын 16-ны өдөр ЗХАНЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон Бүсан хотын Вест Жусон зочид буудалд болсон “Глобал хотуудын форум”-д оролцов. “Олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан газар хөдлөлтийн аюулыг хянах системийг байгуулах” сэдвээр газар хөдлөлтийн эсрэг авах арга хэмжээ, олон талын арга замыг хэрэгжүүлэхийн тулд Бүсан хотын салбарын мэргэжилтнүүд болон Япон улсын Кобэ, Фүкүшима, Гумамото хотуудын салбарын төлөөллүүдийн санал бодлыг сонсоцгоов.



Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Зүүн тэнгисийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад оролцогчдод тусгай илтгэл тавив.

11 дүгээр сарын 19-ний өдөр ЗХАНЗХ(NEAR)-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон Хотын стратегийн судалгааны газарт болсон “Зүүн тэнгисийн мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалт”-д сууж буй хүмүүст зориулж тусгай илтгэл тавив. Ерөнхий нарийн бичгийн дарга “Зүүн тэнгисийн хотуудын сүлжээ” хэмээх сэдвээр тавьсан илтгэлдээ дипломат албанд ажиллаж байсан болон ЗХАНЗХ-нд ажиллаж буй туршлагадаа үндэслэн Зүүн тэнгисийн газар зүй, улс төртэй холбогдуулан улс орнуудын

стратеги, Гёнсанбүг муж, Пухан хотын үүрэг, Зүүн хойд Азийн улс төрийн байдал зэргийн талаар дурдсан нь лекц сонсогчдоос өндөр үнэлэлт авав.



Монгол улсын НИТХ-ын төлөөлөл Холбооны Хэрэг эрхлэх газарт айлчлав.

12 дугаар сарын 7-ны өдөр Монгол улсын НИТХ-ын тэргүүлэгч Н.Баярмөнх тэргүүтэй төлөөлөгчид тус газарт айлчилж, байгууллагын үйл ажиллагаатай танилцав.

Холбооны Хэрэг эрхлэх газрын Төлөвлөлт, Олон нийттэй харилцах хэлтсийн дарга Гүон Нам Вон төлөөлөгчдийг хүлээн авч уулзахдаа “Монгол улсын орон нутгууд тус Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болохыг онцлон хэлж, үүнд талархаж байдагаа илэрхийлээд цаашид гишүүн орон нутаг хооронд мэдээлэл солилцох, орон нутгийн ИТХ-ын үйл ажиллагаанд идэвхтэй дэмжлэг үзүүлэх болно” гэв.



Гишүүн орон нутгуудын мэдээ

Хэйлонжан муж-БНХАУ

33 дахь удаагийн Харбин-Олон улсын цас мөсний фестиваль

2017 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 33 дахь удаагийн Харбин-Олон улсын цас мөсний фестивалийн нээлтийн ажиллагаа болон Олон улсын цас мөсний аялал жуулчлалын дээд хэмжээний 2-р хурал болно. Фестивалийн хугацаанд 18 дахь удаагийн Харбиний цас мөсний ертөнц ба 28 дахь удаагийн Тэяндү-Олон улсын мөсөн сийлбэрийн үзэсгэлэн болохын зэрэгцээ Сунхуа голд цас мөсөн Диснейлэнд паркийг барьж Сталиний цэцэрлэгт том хэмжээний мөсөн сийлбэрүүдийг байрлуулна. Мөн Заорин цэцэрлэгт мөсөн дэнлүүний фестиваль нээгдэнэ. Түүнээс гадна Хэйлонжан мужийн нутгуудад аялал жуулчлалын фестиваль, цас мөсний аялал жуулчлал, цас мөсний спорт, гэрэл зургийн уралдаан зэрэг 116 гаруй төрлийн арга хэмжээг зохион байгуулж, нутгийн эдийн засаг, худалдааг дэмжиж цас мөсний аялал жуулчлалыг идэвхжүүлнэ.



Нигата муж-Япон улс

9 дэх удаагийн Орос, Японы эрчим хүч, байгаль орчны хурал болж өнгөрлөө.

11 дүгээр сарын 2-ны өдөр Япон, Оросын засгийн газар, хувийн хэвшил, судалгааны байгууллагын төлөөлөл оролцсон 9 дэх удаагийн Орос, Японы эрчим хүч, байгаль орчны хурал болж өнгөрлөө. Уг хурлаар Орос, Япон 2 улсын мэргэжилтнүүд эрчим хүчний хамтын ажиллагааны талаар сүүлийн үеийн мэдээллийг солилцдог.

Хурлын нээлтийн илтгэлд хөгжлийн шинэ боломжийг харуулах Орос, Японы харилцааны хэтийн төлөв ба Японы эрчим хүчний бодлогод Орос улс чухал болохыг онцлон дурджээ. Хурлын А хэсэгт “Эрчим хүчний нөөц” сэдвээр дэлхийн эрчим хүчний эрэлтийн чиг хандлага, Алс Дорнодын эрчим хүчний дэд бүтцийн байдал ба Японы компаниудын эрчим хүч нийлүүлэлтийн байдлын талаар танилцуулсан. Хурлын В хэсэгт “Эрчим хүч хэмнэлт, байгаль орчин, цахилгаан” сэдвээр 11 дүгээр сард гарсан Францын хэлэлцээр, Сахагийн БНУ-ын сэргээгдэх эрчим хүч нийлүүлэлтийн өнөөгийн байдал, Японы компаниас хэрэгжүүлсэн салхины эрчим хүчний төслийн талаар танилцуулав. Нигата муж Орос, Японы эрчим хүчний хамтын ажиллагаатай холбогдох мэдээллийн төвийн хувьд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.



Чунчонбүг муж-БНСУ

Сэжун их хааны түр ордон барина.

Солонгосын Сэжун их хаан 123 өдрийн турш биеэ сувилангаа хангыл үсгийг зохиохдоо амьдарч байсан түр ордонь барьж, 2 жилийн дараа ашиглалтад оруулна. Чонжү хотын захиргаанаас Сэжун их хаан Чонвон дүүргийн Нэсүб Чужонни гэдэг газар түр ордон бариулж, тэнд 2 удаа 123 өдрийн турш рашаан ус уух, биеэ угаах зэргээр биеэ сувилуулсан түүхэнд үндэслэн Сэжун их хааны Чужон ордонь барих ажлыг эхлүүлсэн.

Уг ордон нь 1448 онд галд шатаж үгүй болсоноор тодорхой байрлалыг

нь мэдэх аргагүй байсан ч “Шиндун Гүг Ёжисэннам” зэрэг материалд Чужонвоны урд байсан гэж түүхэнд тэмдэглэгдсэн тул Чужон рашааны дэргэд гэж үзсэн. Чужон соёлын цэцэрлэгийн ойролцоо ордонь барин орчин үеийн нөхцөлд тохируулан ашиглах юм. 36.000 м² талбай эзлэх уг ордонь барихад Солонгос улсын төсвөөс 5 тэрбум вон, мужаас 2.5 тэрбум вон, хотоос 4.5 тэрбум вон буюу нийт 12 тэрбум воньг төсөвлөжээ.

Сэжун хотын захиргааны ажилтан “Сэжун их хааны ордонь ашиглалтад оруулсанаар Чужон рашааны баяр, Сэжун хааны ордонь соёлын контенттой холбогдох Чонжү хотын төлөөлөх аялал жуулчлалын бүтээгдэхүүн болно гэдэгт найдаж байна” гээд “Хааны түр байрлаж байсан ордоньг бодитоор байгуулах нь түүхэн үнэ цэнээ өвлүүлэн хадгалахуйц байхаар эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн зөвлөгөөг авч тусгах болно”



Гёнсаннам муж-БНСУ

2018 он гэхэд цахилгаан автомашин цэнэглэх байгууламжийг ашиглалтад оруулна.

Гёнсаннам мужийн Собү захиргааны ордонд 11 дүгээр сарын 10-ны өдөр Солонгосын цахилгаан эрчим хүчний газартай цахилгаан автомашин цэнэглэх дэд бүтцийг байгуулахын тулд “Цахилгаан автомашин цэнэглэх байгууламж барих” талаар гэрээ байгуулав. Энэхүү гэрээг өнгөрсөн 11 дүгээр сарын 6-ны өдөр Солонгосын засгийн газраас нарийн ширхэгтэй тоосны эсрэг арга хэмжээ авахтай холбогдуулан ирэх 2020 он гэхэд 25.000 цахилгаан автомашинийг зах зээлд түгээх зорилттойгоор цэнэглэх байгууламжийг тогтвортой нийлүүлэхийн тулд хийжээ.

Энэ өдөр гэрээ байгуулах ёслолын ажилагаанд Гёнсаннам мужийн захирагчийн орлогч Жу Гю Ил, Солонгосын Цахилгаан эрчим хүчний газрын дэд захирал Ким Ши Ху болон мужийн хот, сумын холбогдох 30 хүн оролцов. Гэрээний гол агуулга нь муж, сум хотуудад байгууламж барих газар олгох, Солонгосын Цахилгаан эрчим хүчний газраас цэнэглэх байгууламж барих, үйл ажиллагааг нь хариуцах байв. Солонгосын Цахилгаан эрчим хүчний газраас ирэх 2018 он гэхэд 4 тэрбум воньг зарцуулан цэнэглэх байгууламж хүрэлцээгүй хот сумдын хүн олноор төвлөрдөг, аялал жуулчлалын зэрэг 50 гаруй газарт барьж цахилгаан автомашин ашиглах нөхцлийг сайжруулах болно.

Гёнсаннам мужийн захирагчийн орлогч Жу Гю Ил “Ирэх жил 300 км явах цахилгаан машинийг нэвтрүүлэх бөгөөд цаашид 2-3 жилийн дотор цахилгаан машиний хэрэглээ ихснэ” гээд “Энэ удаагийн гэрээ нь цахилгаан машины эрин үеийг утгах бэлтгэл болох бөгөөд цаашилбал байгальд ээлтэй машиний хэрэглээг нэмэгдүүлсэнээр хүлэмжийн хийг бууруулахад том хувь нэмэр оруулна” гэв.

Нөгөөтэйгүүр цахилгаан автомашиний үнэ 40 сая орчим вон бөгөөд машин худалдан авахад 17 сая вонь тэтгэлэг 4 сая вонь өртөгтэй хувийн хэрэглээний цэнэглэгч суурилуулагч авах бөгөөд 4 сая вонь татварын хөнгөлөлт эдлэх болно.

January, February

2017. 1. 1. ~ 2. 28

Ангилал	Арга хэмжээний нэр	Хугацаа	Хаана	Харилцах утас
Ганвон муж/ БНСУ	Хуачон-Хулд загасны баяр	1/7~29	Ганвон мужийн Хуачон сум	Хуачон сумын захиргаа, Аялал жуулчлал, бодлогын хэлтэс Tel : +82-1688-3005
Хёго муж/Япон улс	Хёго-Аюулгүй байдлын өдөр 1 сарын 17-ны өдрийг дурсах алхалт 1 сарын 17-ны өдрийг дурсах цугларалт Гамшгаас сэргийлэх сургуулилт	1/17	Кобэ хот	Хёго мужийн захиргааны Сэргээн босголтыг дэмжих хэлтэс Tel : +81-78-362-9984 Fax : +81-78-362-4459
Хёго муж/Япон улс	Олон улсын гамшгаас сэргийлэх, хүмүүнлэгийн дэмжлэг үзүүлэх тухай форум	1/20	Кобэ хот	Хёго мужийн захиргааны Гамшгаас сэргийлэлт, төлөвлөлтийн хэлтэс Tel : +81-78-362-9870 Fax : +81-78-362-9914
Хёго муж/Япон улс	Олон улсын сэргээн босголтын тухай форум 2017	1/24	Кобэ хот	Хёго мужийн захиргааны Гамшгаас сэргийлэлт, төлөвлөлтийн хэлтэс Tel : +81-78-362-9870 Fax : +81-78-362-9914
Киото муж/ Япон улс	Киото-Дэлхийн байгаль орчны зүтгэлтэнд шагнал гардуулах ёслолын ажиллагаа	2/11	Киото хот	Шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах алба Tel : +81-75-414-4830
Киото муж/ Япон улс	Киото-Байгаль орчин, соёл, эрдэм шинжилгээний форум, Олон улсын симпозиум	2/11	Киото хот	Форум зохион байгуулах алба Tel : +81-75-414-4830
Нигата муж/ Япон улс	Зүүн хойд Азийн эдийн засгийн хөгжлийн тухай олон улсын хурал	2/14~15	Нигата хот	Зүүн тэнгисийн судалгааны институт(ERINA) Tel : +81-25-290-5545 Fax : +81-25-249-7550



Сэтгүүлийн 2017 оны дугаараас эхлэн Холбооны гишүүн орон нутгуудын эдийн засгийн салбарын харилцааг идэвхжүүлэхийн тулд аж үйлдвэр, хөрөнгө оруулалт, байгаль орчин зэргийн талаар танилцуулах эдийн засгийн буланг нээж байна.

Гёнсанбүг мужийн тухай товчхон

Гёнсанбүг муж нь эртний Шилла улсын үеэс улбаатай 1000 жилийн түүхтэй Буддын шашны соёл, Гаяагийн гайхамшигт соёл, Күнзийн сургаал зэрэг үндэстэний соёлын өлгий хийгээд соёлын нүүр царай юм.

Эх оронч үзлээр дамжуулан үндэсний хямралыг амжилттай даван туулахад гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Сэ Мауль(Шинэ тосгон) хөдөлгөөн, байгаль хамгаалах хөдөлгөөн зэргийг санаачилж өрнүүлж байсан.

Тус муж 19,029км² газар нутагтай(Солонгосын нийт газар нутгийн 19.1%-ийг эзэлнэ)-н хувьд Солонгост хамгийн том газар нутагтай бөгөөд Сөүл хотын газар нутгаас 31 дахин том юм. Муж нь 10 хот, 13 сум болон баг зэрэг 332 жижиг нэгжээс бүрдэнэ.

Гёнсанбүг муж нь зүүн эргийн дагуу 335 км урттай хүний гар хүрээгүй байгалийн унаган төрхөө хадгалж үлдсэн газартай, дэлхийд алдартай төмөрлөг гангийн үйлдвэртэй, бөс даавуу үйлдвэрлэлийн төв болохын хувьд улсын эдийн засгийн өсөлтийн хөдөлгөгч хүч болж ирсэн. Мөн тус мужид Өмнөд Солонгост Сөүлийн дараа орох хамгийн олон 38 их, дээд сургууль байдгийн хувьд судалгаа, технологийн боловсон хүчний нөөц ихтэй.

Дотоодын соёлын өвийн 20% тус мужид байдаг ба аялал жуулчлал, соёлын хувьд өндөр хүчин чадалтайг илтгэн харуулахын зэрэгцээ дэлхийн соёл, аялал жуулчлалын төв болон хөгжиж байна.

Бид энэ удаагийн дугаартаа Гёнсанбүг мужийн Пухан хот дахь хурдасгуурын лаборатори, дэлхийд алдартай Поско компани, Сэ Мауль(Шинэ тосгон) хөдөлгөөн гэх мэт мужийн эдийн засгийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын орчин зэрэг төрөл бүрийн мэдээллийг бэлтгэн танилцуулж байна.

• Аж үйлдвэрийн бүс(км²)

Ангилал	Тоо		Улсын зэрэглэлийн аж үйлдвэрийн бүс		Ердийн аж үйлдвэрийн бүс		Хөдөө аж ахуйн бүс		Бусад
	Бүсийн тоо	Эзлэх талбай	Бүсийн тоо	Эзлэх талбай	Бүсийн тоо	Эзлэх талбай	Бүсийн тоо	Эзлэх талбай	
Нийт	156	155,180	9	83,724	78	59,766	69	11,690	

• Улсын зэрэглэлийн аж үйлдвэрийн бүс-Эдийн засаг, чөлөөт худалдааны бүс

Гүми хот дахь Өндөр технологийн цогцолбор

• 2009-2014 онд 9.34км² газарт барьж, 1 триллион 722 тэрбум 800 сая воны хөрөнгө оруулалт хийсэн.
•Электрон мэдээлэл, механиктоникс, шинэлэг материалын хөрөнгө оруулалт

Пухан хот дахь аж үйлдвэрийн цогцолбор

• 6.12км² газарт 2009-2014 онд барьж, 856 тэрбум 800 сая воны хөрөнгө оруулалт хийсэн.
•Ган төмөрлөг, тоног төхөөрөмж, усан онгоц, автомашиний эд анги, эрчим хүчний чиглэл

Дэгү хот-Гёнсанбүг мужийн Эдийн засгийн чөлөөт бүс

• 2008-2020 онд 8 бүс бүхий 19.72км² газарт 817 тэрбум воны хөрөнгө оруулалт хийнэ.
•Гёнсанбүг мужийн 5 бүс(Гүми, Ёнчон, Гёнсан гм) бүхий 21.6км² газрыг хамарна.

※ Аж үйлдвэрийн бүсийн өнөөгийн байдал

- 156 газар(Улсын зэрэглэлийн 9, Ердийн 78, Хөдөө ахуйн 69), 154км² газарт

- Улсдаа аж үйлдвэрийн хүчин чадлаар 2-рт ордог.


Гёсанбуг мужаас НҮБ-тай хамтран өрнүүлдэг Сэ Мауль хөдөлгөөн

Гёсанбуг муж Сэ Мауль буюу Шинэ тосгон хөдөлгөөнийг дэлхийд өрнүүлэн үүгээр дамжуулж хүний ухамсарыг өөрчлөхөд гол анхаарч байна. Солонгос улс ядуурлыг даван туулсан туршлагаа олон улсад өвлүүлж хөгжиж буй орнуудын хөгжилд дэмжлэг үзүүлэн дэлхийн ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилгоор уг хөдөлгөөнийг эхлүүлсэн юм.

Тус муж одоо эрэлт, оролцоонд суурилан нутгийн иргэдийн санаачлагатай Сэ Мауль хөдөлгөөнийг өрнүүлэхийн тулд тив бүрт Сэ Мауль судалгааны институт байгуулан анхан үед нь нутгийн иргэдэд зориулсан болон хөдөлгөөний удирдагч бэлтгэх сургалтыг түлхүү явуулж, урт хугацаанд удирдагч ба сургагч багш нарын сургалтыг явуулах Сэ Мауль хөдөлгөөний төв болгох юм. Түүгээр ч зогсохгүй гадаадад жишиг тосгон байгуулан Сэ Мауль хөдөлгөөний удирдагчдыг илгээдэг. Мөн буурай хөгжилтэй орнуудад Сэ Мауль хөдөлгөөний удирдагч бэлтгэх сургалт явуулахаас гадна Солонгос оюутнуудыг гадаадад уг хөдөлгөөний хүрээнд сайн дурын үйл ажиллагаанд оролцуулдаг. Одоог хүртэл 86 улсын 4297 хүн Сэ Мауль хөдөлгөөний удирдагчийн сургалтад суусан бөгөөд 11 улсад 30 Сэ Мауль жишиг тосгон байгуулсан. Мөн 6 улсын 610 оюутан хилийн чанад дахь сайн дурын үйл ажиллагаанд оролцсон.

Цаашид Солонгосын төр засгийн хэмжээнд Сэ Мауль ODA буюу албан ёсны тусламжийн байгууллагыг байгуулахаар төлөвлөж буй бөгөөд Сэ Мауль хөдөлгөөнийг дэлхийд таниулах, орон нутгуудад улсын чанартай дэмжлэг үзүүлэх юм.





Гэрлэн хурдасгуурын лабораторид бараг бүх судалгааны чиглэл болон судалгааны хамтын ажиллагааг явуулах боломжтой мэдээлэл технологи, нано технологи, биотехнологи зэргийг хөгжүүлэхээс авахуулаад хэрэглээний, аж үйлдвэрийн салбарт хүртэл эдийн засгийн их үр нөлөөтэй. Цаашилбал гэрлийг ашиглан гаргаж болох дараа үеийн хөгжлийн шинэ хөдөлгөгч хүчийг хослуулсан технологийг гаргахад анхаарч байна.

posco

Поско-Ган төмөрлөгийн үйлдвэр



1968 онд байгуулагдсан тус компаний үйлдвэрлэлийн хүчин чадал 38 сая тоннд хүрэх ба дэлхийн түвшний төмөрлөгийн компани болохын хувьд ороомог, хавтан, цувимал, электрон ган, тусгай зориулалтын ган, гадаргуут нь бүрсэн ган зэрэг нүүрстөрөгчийн ган болон зэвэрдэггүй ганг үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангахаас гадна гадаадад гаргаж байна.

Одоо дэлхий дахинд ган төмөрлөгийн эрэлт багассанаар Хятад зэрэг дэлхийн улс орнуудад гангийн хэт их үйлдвэрлэл, илүүдэл тоног төхөөрөмжийн асуудал гарч буй үед Хятадаас ган төмөрлөг экспортолох нь ихэссэн, иений ханш бууралт, дотоодын эрэлт зогсонги байгаа зэрэг асуудлаас үүдэн санхүүгийн бэрхшээлтэй байгаа ч ‘POSCO the Great’ гэсэн уриатайгаар дэлхийд өрсөлдөх чадвараа хадгалахад анхаарч байна.

Тус компаний Гуанян дахь үйлдвэрт дэлхийд хамгийн их хэмжээгээр хавтан үйлдвэрлэдэг ба Пухан дахь үйлдвэрт хайлш гаргах 4 тогоотой.

Дэлхийн чанартай ган төмөрлөгийн чиглэлээр анализ хийдэг WSD(World Steel Dynamics) байгууллагаас өнгөрсөн 6 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан 30 дахь удаагийн ган төмөрлөгийн стратегийн хурлаар “Дэлхийд хамгийн өрсөлдөх чадвартай компани”-ийг шалгаруулан зарласан бөгөөд Поско компани 6 жилийн турш 8 удаа эхний байранд шалгарсан. Мөн уур амьсгалын стратеги, хөдөлмөрлөх хүчний эрх, хүний нөөцийн хөгжил зэрэг ангилалд дээд зэргийн үнэлгээ авсан. Түүнээс гадна 11 жил дараалан “Тогтвортой менежменттэй шилдэг компани”-аар шалгарч Солонгосын компаниудаас удаан хугацаанд дэлхийд нэрээ дуурсгаж байна.

NEAR 2016-Олон улсын форум



11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд БНСУ-ын Гёнсанбүг мужийн Андун хотноо NEAR 2016-Олон улсын форум болж өнгөрлөө. Форумд Монгол, Орос, Солонгос, Хятад, Япон 5 улсын 35 орон нутгийн 85 хүн оролцов. Энэхүү форумыг ЗХАНЗХ-ны Хэрэг эрхлэх газар болон Солонгосын Аялал жуулчлалын нийгэмлэгээс хамтран “Зүүн хойд Азийн орон нутгуудын аялал жуулчлалын хамтын ажиллагаа” сэдвээр зохион байгуулав. Дагалдах сэдвүүдийн дагуу илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд Зүүн хойд Азийн орон нутгуудын аялал жуулчлалын бодлого, амжилттай хэрэгжүүлсэн туршлагын талаар танилцуулав.

● Нээлтийн ажиллагаа

Форумыг нээж ЗХАНЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Жон Жэ Вон үг хэлж, дараагаар нь Гёнсанбүг мужийн захирагчийн орлогч Жон Бён Юн, Андун хотын захирагч Гүон Ён Сэ нар мэндчилгээ дэвшүүлж, Солонгосын аялал жуулчлалын корпорацийн захирал нээлтийн илтгэлийг, АНУ-ын Төв Мичигений их сургуулийн багш Евгений Ру тусгай илтгэлийг тус тус тавив.

● Сэдэв бүрээрх илтгэл, хэлэлцүүлэг

Аялал жуулчлал ба орон нутгийн хөгжил, тогтвортой аялал жуулчлал ба олон улсын хамтын ажиллагаа, Зүүн хойд Азийн аялал жуулчлалын хамтын ажиллагаа гэсэн 3 сэдвээр илтгэлүүд тавьсан. Монгол, Орос, Солонгос, Хятад, Япон улсуудын аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүд уг форумд уригдан оролцож, орон нутгуудын аялал жуулчлалын бодлого, тэргүүний туршлагын талаар танилцуулж дараагаар нь хэлэлцүүлэг өрнүүлэв.

Форумын 1-р хэсэгт Японы Рисмэйкан Ази Номхон далайн их сургуулийн багш Хатада Нубүюки Мачицүри аялал жуулчлалын газрын тухай танилцуулсан бол Оросын Сахалин их сургуулийн багш Элвира Им Сахалин мужийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын тухай танилцуулсан. Форумын 2-р хэсэгт Монголын Үндэсний их сургуулийн багш С.Мөнхнасан





Монголын эко аялал жуулчлал, аялал жуулчлалын төслийн талаар танилцуулсан бол Солонгосын Дангүг их сургуулийн багш Ким Хён эко аялал жуулчлалын тухай тодорхойлолт, бодлогын асуудлын талаар илтгэлдээ онцлон хэлэв. Форумын 3-р хэсэгт Хятадын Хэнан их сургуулийн багш Чэн Нан Хятадын нэг бүс-нэг зам бодлоготой уялдах Хятадын аялал жуулчлалын бодлогын талаар танилцуулав. Солонгосын Соёл аялал жуулчлалын судалгааны хүрээлэнгийн доктор Чэ Гён Эн Зүүн хойд Азийн аялал жуулчлалын харилцааг идэвхжүүлэх талаар танилцуулав.

Форумын үеэр улс бүрээр аялал жуулчлалын үзэсгэлэн гаргаж Зүүн хойд Азийн орнуудын соёл, аялал жуулчлалыг танилцуулан форумд оролцогчдод Зүүн хойд Азийн улс орнуудын талаарх ойлголтыг нэмэгдүүлэв.

● Форумын дараах хөтөлбөр

Форумын дараах өдөр зочид төлөөлөгчид Гёнсанбүг мужийн захиргааны ордон, дэлхийн соёлын өвд бүртгэлтэй Хакы тосгон зэрэг газруудаар аялав.



Хүүхэд сурагчдад зориулсан 4 дэх удаагийн эссэ бичлэгийн уралдааны шагналт байрын бүтээлүүдээс толилуулах нь

Холбооны гишүүн болох Зүүн хойд Азийн орон нутгуудын 14-18 насны хүүхэд, сурагчдийн дунд эссэ бичлэгийн уралдааныг 2013 оноос эхлэн зохион явуулж ирсэн бөгөөд энэ жил гар зураг, постерийн уралдааныг давхар зохион явуулсан. Гар зураг, постерийн уралдааныг “Соёлын өвийг хамгаалах нь”, “Байгаль орчны асуудал” гэсэн сонголттой сэдвээр зарласны дагуу нийт 5 улсаас 46 бүтээл ирсэн. Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт эссэ бичлэгийн уралдааны тэргүүн болон дэд байрын бүтээлээс нийтэлж байна.

<Тэргүүн байр>

Зүүн хойд Азийг танин мэдэж,
ирээдүйнхээ талаар мөрөөдөцгөө

**БНСУ - ын Гёнсанбүг мужийн Гёнсан
эмэгтэйчүүдийн дунд сургуулийн сурагч Бэ Га
Хён**

Дэлхийн арван гуравны нэг хувьд хүрэхгүй газар нутагт дэлхийн хүн амын тавны нэг нь орших ба дэлхийн нийт үйлдвэрлэлийн дөрөвний нэгд хүрэх эдийн засгийн хүчин чадалтай, Азийн өргөн уудам эх газар, Номхон далайд гарцтай тэрхүү газар бол бидний амьдралын үндэс болсон Зүүн хойд Ази юм. Аж үйлдвэрийн хувьсгалаас хойш Европын хүчирхэг улсууд дэлхийн төвд байсан. Дэлхийн 2-р дайнаас хойш Америк улс хамгийн их хүчирхэгжсэн. Мэргэжилтнүүд Зүүн хойд Азийг дэлхийн төвд байх болно гэж таамагладаг. Ийм ч учраас бид Зүүн хойд Азийг танин мэдэх хэрэгтэй.

Зүүн хойд Азийг танин мэдэхийн тулд бид эхлээд Зүүн хойд Азийн талаар анхаарч сонирхдог байх хэрэгтэй. Зүүн хойд Азийн улс орнууд ямар онцлогтой хийгээд мөн ямар үйл явдал өрнөж буйг ном сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэх хэрэгтэй. Зүүн хойд Азийн нийгэмлэг, Зүүн хойд Азийн соёлын сан, Зүүн хойд Азийн энхтайвны холбоо тэрчлэн энэхүү уралдааныг зохион явуулсан ЗХАНЗХ зэрэг байгууллагуудын сайт мэдээллийг ашиглан дам бусаар мэдэж ч болно. Мөн Зүүн хойд Азийн аялал зэрэг хөтөлбөрт оролцож мэдэх арга ч бий.

Өнгөрсөн жил би өөрийн төрөлх нутаг болох Гёнсан хоттой ах дүүгийн харилцаатай Япон улсын



Зыюу хотод айлчилсан. Хамгийн сэтгэлд үлдсэн зүйл бол Япон улсын Зыюу дунд сургуулийн сурагчидтай уулзсан явдал байсан. Анхандаа сайн хэл нэвтрэлцэхгүй, биеэ барьцгааж байсан. Энэ үед санамсаргүй байдлаар Солонгосын соёлын давалгааны талаар яриа эхэлсэн. Япон хүүхдүүд Солонгосын жүжигчдийн талаар ярьж эхлэхэд ярих юмтай болж бид амархан дотноссон. Нөгөөтэйгүүр “Бид ч Японы талаар урьдаас мэдэж явсан бол очоод ярих юмтай, ойртон нөхөрлөхөд илүү амар байсан байх” гэсэн харамсал төрсөн. Энэ мэтчилэн өөрийн болон бусдын соёлыг мэдэх нь харилцан нөхөрлөх хэрэгсэл болдог.

Гэхдээ Зүүн хойд Азийн түүх, уламжлал, соёл зэргийн талаар өнгөц мэдэх нь нэмэргүй юм. Солонгосын зүйр цэцэн үгэнд “Турван ширхэг шүр ч байсан хэлхэж байж эрдэнэ” гэсэн үг байдаг. Мөн дорнын гүн ухаантан Күнз “Эрдэм мэдлэгийг сурч бодож тунгаахгүй аваас харанхуй мунхаг, бодон тунгаавч сурч мэдэхгүй аваас аюултай” гэсэн байдаг. Бид Зүүн хойд Азийн тухай мэдэх болсон зүйлээ баяжуулан улс орнуудын түүх, соёл уламжлалыг ойлгох, үүнд хандах байдлаа ч хөгжүүлэх хэрэгтэй. Түүнчлэн Зүүн хойд Азийн ирээдүйн талаар бодож мөрөөдөх хэрэгтэй. Энэ нь Зүүн хойд Азийг жинхэнээр мэдэх арга зам юм. Үүний жишээ болгож Зүүн хойд Азийн түүхийн асуудлыг дурдаж болно.

Зүүн хойд Азийн улс орнууд түүхэнд хоорондоо нягт харилцаатай байсан. Үүнээс улбаалан өнгөрсөн түүхийн олон асуудал одоо ч шийдэгдэж чадаагүй байгаа бөгөөд улс орнуудын сэргэлдөөн даамжирах тохиолдол их байна.

Япон цэргүүд Солонгос охид бүсгүйчүүдийг сексийн хэрэгцээнд боолчилж байсан асуудал, Нанжиний их хядлага төлөөлөх асуудал юм. Мөн түүхэн хүчин зүйлээс үүдэн гарсан Дугду арал, Сенкакү арлын маргаан ч бий. Энэ мэт асуудал нь харилцан нэг нэгнийгээ сайн мэдэж чадаагүйгээс үүссэн юм. Франц, Герман улсыг жишээгээр харахад тэд нэг нэгнийгээ ойлгож, өөрсдийн түүхэн гэмт хэргийн талаар хүлээн зөвшөөрсөнөөр хоёр улсын харилцаа эрс хөгжсөн. Эдгээр 2 улсын хөгжилд ч энэ нь эерэгээр нөлөөлсөн. Энэчлэн бид бие биенийгээ ойлгон мэдэх хэрэгтэй.

Зүүн хойд Азид газар нутаг, түүх, соёлын өв, цэргийн сургуулилт зэрэгтэй холбоотой олон маргаантай асуудал гарч байдаг. Бид нэг нэгнийгээ сайн ойлгох юм бол тэр тусмаа Зүүн хойд Азийн ирээдүйн эзэд болсон хүүхэд залуучууд Зүүн хойд Азийн талаар сайн мэдэх юм бол Зүүн хойд Азийн ирээдүй улам гэгээлэг байх юм. Хятад, Солонгос, Япон түүнчлэн Хойд Солонгосын миний үеийн хүүхдүүд бүгд нэгэн гэр бүл шиг байж, харилцан туслалцаж итгэл найдвар бүхий ирээдүй рүү тэмүүлэх сайхан биш гэж үү? Үүний тулд бидний хийх ёстой анхны алхам бол чухамдаа “Зүүн хойд Азийг таньж мэдэх” юм.



<Дэд байр>

ОХУ-ын соёлын одоо ба ирээдүйн

талаарх миний бодол

ОХУ - ын Хабаровск мужийн Тэнгисийн цэргийн дунд сургуулийн сурагч Пашюта Анна

Би өөрийн эссэ бичлэгийн эхэнд ОХУ-ын соёлын талаар цөөн үг бичье гэж бодлоо. Ихэнх гадаадын иргэд Орос гэжээр л балалайк хөгжим, хүрэн баавгай, чихэвтэй малгай, залуу гэж төсөөлөн боддог. Гэвч энэ нь хөдлөшгүй үнэн зүйл биш юм. Өнө эртний түүхээс улбаатай олон төрлийн заншил, уламжлал соёл, баяр ёслол байдаг. Орост өргөн дэлгэр тэмдэглэдэг уламжлалт баяр ёслол тэр дундаа өвлийн улиралд тэмдэглэдэг: Шинэ жил, Шинэ жил эхэлсний баяр(Старый новый год), Зул сарын баяр, Эзэн харгалсан өдөр(Эпифани)-ийн баяр, Христийн Мэндэлсний Баяр, Өвөл өнгтэй дуусч урин хавартай золгосны баяр/Масленица/ зэрэг олон баяр байдаг. Ихэнх баяр ёслол нь слав соёлоос үүсэлтэй ба Оросын ард түмний дунд хамгийн дуртай, түгээмэл тэмдэглэдэг болсон.

Орос орон бол маш хүнд бэрх үеийг туулж өнгөрүүлсэн баатарлаг түүхтэй. Манай улс олон дайн тулаанд явцалт байгуулж байсан учраас Бородини тулалдаанд ялсан өдөр гэх мэчилсэн маргадлашгүй тэмдэглэлт өдрүүд олонтой. Гэвч Аугаа их эх орны дайн хамгийн аймшигтай, маргадлашгүй нь байсан. Тиймээс Ялалтын баярын өдөр ОХУ-ын ард түмний хувьд хамгийн том баяр юм.

Манай ард түмний соёл нь ардын дуу, бүжиг, шидэт үлгэр домог, дуу хөгжим, хөгжмийн зэмсгээр маш баялаг. Мөн өвөрмөц олон төрлийн спортууд сайн хөгжсөн. Хүмүүс эдгээр спортоор хичээллэж тухайлбал бартаатай ууланд авирах гэх мэт сонин содон үзүүлбэрийг Масленица шиг баяр амралтын үеэр бэлтгэн үзүүлдэг.

Үүнээс гадна Орос улсын үндэсний онцлогийг харуулсан шаазан эдлэл, аяга таваг (Гжель), модон халбага-чимэлтэлтэй модон эдлэл (Хохлома), Оренбургийн нэхмэл алчуур, Димковын тоглоом, Уралын ногоолын эдлэл, Тульскийн халуун тогоо(самовор) зэрэг бүтээлч зүйлүүд ихтэй. Эдгээр бренд бүтээгдхүүнүүд нь жуулчдын дунд одоо ч алдартай, сонирхлыг нь татсаар байна.

Би ОХУ-ын олон төрлийн амтат хоол болон гэрийн эзэгтэйн зочломттой занг дурдахыг хүсч байна. Үнэндээ та орос гэр бүлд зочлолц гэрийн эзэгтэй нь хөрөгчиндөө байгаа бүхнээ ширээн дээр дэлгэн тавих болно. Үүнээс гадна, “Оросын аугаа сэтгэл” гэсэн дэлхий даяар алдартай хэллэг байдаг. Энэ үгээр сэтгэлийн хөдөлгөөнтэй, элэгсэг дотно, өгөөмөр зан чанартай миний ард түмний унаган төрхийг илэрхийлсэн гэж бодож байна.

Оросын уран зохиол болон соёл нь дэлхийд алдартай. Тухайлбал: Зохиолч Александр Пушкин, Лев Толстой, Михаил Булгаков, зураач Виктор Васнецов, Иван Айвазовский, Исаак Левитан, Карл Брюклов, Казмир Малевич, алдарт эрдэмтэн Менделеев, Ломоносов, Попов, Яблочков, сансрын нисэгч Гагарин болон Трешкова, балетийн бүжигчид Мария Плесетская, Анна Павлова, Анастасия Волочкова гээд дэлхий даяар нэрээ дуурсгасан олон алдартантай билээ.

Орчин үеийн Оросын соёл урлаг аажим аажмаар өөрчлөгдөн шинэчлэгдэж байна. Тухайлбал, телевизээр Марина Голубын дурсгалд зориулсан “Гэр бүл”, “Найзууд” гэх мэт энгийн хэрнээ

сэтгэл хөдөлгөсөн кино болон “Барбоскины”, “Смешарики”, “Маша ба Баавгай” гэх мэт хүүхэддэйн кинонууд гарч байна. “Союзмультфильм”-ийн хүүхэддэйн кино болон “Багачуудаа тавтай нойрсоорой” телевизийн шоу нэвтрүүлэг нь өнөө үеийн олон хүүхэд, насанд хүрэгчдийн хүндэтгэл талархлыг хүлээж байна. “Турван баарууд”, “Иван Царевич ба саарал чоно”, “Алёша Попович ба Тугарин могой” зэрэг олон хүүхэддэйн кинонууд кино театрт гарч байна. Түүнээс гадна, ном унших, үзэсгэлэн, музей үзэх, кино театрт очих тэнд шинэ найз нөхөд, танилтай болох зэргээр чөлөөт цагаа соёлтойгоор өнгөрүүлдэг.

Соёл нь улс орон бүрт хамгийн нөлөө бүхий, чухал ач холбогдолтой юм. Хүний дотоод мөн чанарт хүчтэй нөлөөлж, хүний үйл ажиллагаагаар илэрч гардаг үнэт зүйл юм. Соёл гэдэг нь технологи, зураг урлал, уран барилга, оюун санааны амьдрал, шашин шүтлэг, кино, театр, хөгжим, хүний сонирхол, зан төлөв зэрэг маш олон төрлөөс бүрдсэн цогц ойлголт билээ.

Мөн хорин нэгдүгээр зууны даяарчлал нь улс орны хөгжлийн нэг хэсэг юм.

Орчин үеийн ОХУ-ын соёл дэлхийн бусад олон орны адил даяарчлагдаж байна. Даяарчлал гэдэг нь дэлхий нийтийн соёл дэвшилтэт технологи, харилцаа холбооны үр дүнд хөгжиж байна гэсэн санааг илэрхийлнэ.

Энэ үйл явц нь 21-р зууны ОХУ-ын соёлын хөгжилд хэрхэн нөлөөлж байна вэ? 22-р зуунд бид Оросын соёлоос юу хүлээж болох вэ?

Нэг талаас даяарчлалд сул тал бий. Нэгдүгээр, олон залуучууд соёлын үнэт зүйлс болон нийгмийн тодорхой нэг бүлгийн өвөрмөц хэв маягт хэт авгаж байгаа бөгөөд энэ нь тэдний эргэн тойронд байгаа хүмүүст үргэлж сайнаар нөлөөлөөд байдаггүй. Учир нь олон төрлийн соёлын үнэт зүйлсийн зэрэг нөлөө ба сөрөг үр дагавар хоорондын ялгаатай байдал нь залуучуудад заримдаа төвөгтэй байх нь бий. Тухайлбал ОХУ-д чанга хөгжим тавиад мотоцикль унаж давхисад(Байкеры), өөрсдийн үс, толгой болон нүүр амаа элдэв бусаар засаж будагчид(Скинхеды, Эмо, Гот), этгээд чамин стиль загвартай, онцгой өнгөтэй хувцас, малгай өмсөж чамирхай(хиппи, готники) зэрэг барууны орнуудаас нэвтэрсэн доод түвшний соёлын төрөл зүйл байдаг. Эдгээр бүлгүүдийн танхай үйлдэл нь нийгэмд зарим талаараа сөрөг үр дагаварыг дагуулдаг.

Соёлын иймэрхүү төрөл зүйл бол соёлын үндсэн ойлголтоос ялгаатай зүйл юм. Хоёрдугаарт, соёлын нөлөөнд хэт авгагсад тухайн соёлынхоо өв уламжлал, үнэт зүйлсийг мартагдах хүрдэг. Бид өөрийн үндэсний соёлын өв уламжлалаа хамгаалж, хадгалан үлдэх хэрэгтэй. Хүн бүр өөрийн ашиг сонирхолд нийцүүлж соёлыг сонгох эрхтэй боловч энэ нь өөрийн соёлыг сүйрэлд хүргэх биш, анхааралтай, ухаалаг хандах хэрэгтэйг сануулж байна.

Харамсалтай нь өнөөдөр ОХУ-ын сургууль, коллеж, их дээд сургуулиудад уран зохиол, түүх нь оюутан сурагчдад маш чухал

хичээл биш гэж тооцогдох болжээ. Гэвч өөрийн улсын өнгөрсөн үеийн тухай мэдлэггүй бол бид үнэ цэнэтэй сайхан ирээдүйг бүтээж чадахгүй шүү дээ.

Нөгөөтгэйгүүр, даяаршлын үйл явцад маш олон давуу тал байна. Юуны өмнө энэ нь хүний сэтгэлгээний цар хүрээг өргөжүүлэх, соёлын өвийг баяжуулахад тусалдаг. Жишээ нь 21-р зууны ОХУ-ын хүмүүс шинэ төрлийн сонирхолтой болсон. Тэд барууны орнуудаас модон сийлбэр, мэндчилгээ талархал илэрхийлэх зурагт хуудас, ил захидал, олон үетэй амтат бялуу болон олон төрлийн йогийн дасгалуудыг Энэтхэгээс хуулбарлаж авсан.

Орчин үед Орос улсад газар нутгийн ерөнхий үзмэжийг төрөл бүрийн дизайнаар цэцэгжүүлэн тохижуулах урлаг идэвхтэй хөгжиж байна. Оросын залуучууд нийтээр хийдэг флаш моб бүжигт оролцох, нөхөйн шоу, хуучин загварын машины шоу гэх мэт янз бүрийн шоу, рок хөгжмийн баяр наадамд очих дуртай бөгөөд барууны баяр болох Гэгээн Валентины өдөр болон Сүнсний баярыг ч тэмдэглэдэг болсон.

Өнөөдөр маш олон Оросууд Италийн пицца, гоймон, Японы суши болон Хятадын өвөрмөц хоолгүйгээр өөрсдийн амьдралыг төсөөлж ч чадахгүй болжээ.

Гэвч өөр улс орны хүмүүс бич, улаан манжинтай борц шөл, банш, солянка, квас болон архи гэх мэчилэн оросын хоол хүнсний илүүд үздэг.

Даяарчлалын бас нэгэн чухал зүйл бол улс орнуудын хоорондын хил хязгаарыг устгаж харилцан ойлголцолыг бий болгон, бие биенээ хүндэтгэж хандлагыг тогтоосноор бүх дэлхий даяараа амар тайван амьдрахад нь туслах явдал юм. Түүнээс гадна даяарчлал нь аялагчдын хувьд маш ашигтай зүйл болоод байна. Хэрэв та гадаадад аялахаар шийдсэн бол очиж буй улс орныхоо соёл, ёс заншлын талаар судалж мэдэн соёлын цочирдолд орохоос зайлсхийх хэрэгтэй. Олон улс орнуудын соёлын талаар мэдлэг мэдээлэлтэй болсон хүн дараа нь бүхэл бүтэн ертөнцийн соёлоос ч суралцаж хүргэж эрхтэй.

Эцэст нь хэлэхэд соёлгүй байдал ёс суртахуунгүй зан гаргахад хүргэж улмаар зөрчил, гэмт хэрэгт хүргэдэг гэдгийг хэлмээр байна. Би ОХУ-ын соёлын үнэ цэнийг үнэлж, хүндэтгэж сурах юм бол бид угсаатны соёлын өв уламжлалаа үеийн үед хадгалан үлдэж чадна гэж бодож байна.

Ирэх зуунд хүмүүсийн дийлэнх нь соёлын үнэт зүйлс, даяаршлын үйл явцад илүү болгоомжтой ханддаг болно гэдгийг таамаглаж байна. Бид 22-р зуунд өөрсдийн гэсэн өвөрмөц, хосгүй соёлын өвөө устгалгүйгээр хадгалж чадна гэдэгт итгэлтэй байна.

Би англи хэлэнд дурладаг учраас өөрийн үзэл бодлоо англи хэлээр илэрхийлж бичихээр шийдсэн юм. Даяаршлын буй өнөө цагт энэ дэлхийн бүх хүмүүс англи хэлээр харилцаж чадна гэдэгт би итгэлтэй байна. Би англи хэлийг ирээдүйд олон жилийн туршид дэлхий нийтийн хэл байсаар байна гэж бодож байна.

<Дэд байр>

Навчны эргэцүүлэл

Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын 3-р БДС 12а ангийн сурагч Б.Отгончимэг

Тэнгэр ээж ханатал уйлж, газар аавыг умдаалсны дараа нар гийхүйеэ үест цэлгэр таван ханатыхаа өрхийг татаж, хаяаг сөхчихөөд бүйлсэн нүдэт охин би бичиж эхлэв.

Гэрэл, сүүдэр хэмээгч нь юм бүхний хоёр тал ажээ. Гэвч гэрэлтэй тал нь их бол юутай сайнсан.

Эдүгээ Монгол минь дэлхийн чээжинд ургасаар навч нахиагаа дэлгэсэн нэгэн сайхан “залуу мод” болжээ. Наран гийхэд мод улам өндөр ургах ч түүнийг дагаад “сүүдэр” ургана.

“Залуу” хэмээхийн учир гэвээс төрт улс үүсэж, Монгол хэмээх модны үрийг газарт цацсанаас хойш өнө удаан жилүүдэд ургасан ч хагдарч, үндэс сууриа хөндүүлэн гэмтэж, дэлгэрсэн ч он цагийн шуурганд бүдэчсээр социализмын үед газар дор үндэс юу нь нахиаж, ерээд онтой золотол, “ардчиллын үр” бордоо болон цацагдаж, өндийн ургасаар, бат сууриа олж, шинэ тавцанд гарч билээ.

Энэ залуухан модны чанх урд, хойд талд нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс хэмээх “сүрлэг” том модод, ойр орчимд нь Бүгд Найрамдах Солонгос Ард улс, Япон, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос улс зэрэг үр жимсээ дэлгэсэн модод хаяа хаяагаа залган ургана. 1996 оны 9-р сараас хойш энэ хэдэн модод үндэс юугаараа барьцалдаж, мөчир нахиагаа холбож дэм дэмэндээ ургасаар өнөөг хүрсэн авай.

Өдгөө бид бүсчлэн нэгдэж хамтдаа хөгжин дэвшиж “Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо” гэх нэгэн том гэр бүл, ойн нэгэн төгслийг бүтээж, дэлхийн тулах цэг, хөгжлийн төв болох, амар тайван аз жаргалын диваажинг цогцлоохын төлөө эрхэм зорилтуудыг өмнөө тавьж гар гараасаа барилцсан ч өндөр ургасан моднуудын сүүдэр юуг нь яалтай.

Сүүдэр гэгч нь цаг үеэ дагаж хувьсан өөрчлөгдөх “регресс” буюу нийгэмд бий болж буй сөрөг зүйлс юм. Өнөө цагийн байгаль орчны гамшгийн асуудал, уур амьсгалын өөрчлөлт, үзэл санааны доройтол, алагчлал зэрэг нь сайхан ургаж буй моддын сүүдэр болон сүүтэгнэнэ. Аан гэхдээ “гарц” гэж байх юм. Гарцыг хамтдаа эрж хайж, байхгүй бол бий болгохын төлөө эдгээр улсууд нэгдсэн гэдгийг бядлаж буй ухаандаа биежүүлнэ би.

Юутай чухал. Нэгэн агаараар амьсгалж, нэгэн газар дээр хаяа нийлэн орших бидний хэдэн улс эв саналаа нэгтгэж, сүүдэр бүхнийг гийгүүлэхийн төлөө атгасан гар шиг зүтгэнэ гэдэг. Нөгөөтэйгүүр бодохуйяа орой дээр нь хэдхэн хүн гэрэл бариад, сайн сайхны төлөө зүтгэвээс өөр нэг өнцөгт нь сүүдэр заавал гарна даа. Иймийн тул

Монгол гэх модны 21 мөчир дээр бие биенээсээ салаалан ургасан 3,093,143 гаруй навч нахиа бид бүгдээрээ өөр өөрсдийн оюун ухаанд сайн сайхныг бүтээх түүчээ болсон гэрлийг асааж, саар муут өчүүхэн бага дээр нь барьж зогсоож, гэрэлгүй нэгэндээ өөрөөсөө гэрэл өгч асааж гэмээнэ тэнд сүүдэр үгүй болно гэж эргэцүүлнэ.

Гэрэл хэмээгч нь миний төсөөллөөр хүн чанар, мөн чанар, хүнлэг байдал, шударга ёс, биесээ гэх, байгалиа гэх, эх орноо гэх халуун сэтгэл, өгөхийн төлөө, хамгаалахын төлөөх зүрх сэтгэл, эрх тэгш байдал, сэтгэхүйн гэгээ буюу нийгмийн сайн сайхан /прогресс/ юм. Бид хилийн шугамаар тусгаарлагдан бие даан дор бүрнээ орших боловчиг бидний зүрх сэтгэл, үйлс бүхэн нэгнээ гэх сэтгэл бүхэн минь элдэв ханаар тусгаарлагдаж хэрхэвч болохгүй. Эцсийн эцэст амьд бүхэн хамгийн чухал шүү дээ. Дөнгөж нахиаалан буй, бяцхан зүрх сэтгэлийг сүүдэрт сэвтээхгүй байх нь, баян ядуу, элдэв өнгө харж алагчлахгүй байх нь, нэг нэгнээ, байгаль ижийгээ, ус ургамал амьтдыг хамгаалах нь бид юм. Тэгэх л гэж, ядуу дорой нэгэндээ гараа сунгах л гэж, урсаж буй тунгалагхан горхийг хамгаалах л гэж, байгаль ээжээ эрүүл урт наслуулах гэж, өвөр дээр нь жаргалтайхан өсөн торних гэж ... бид хичээж, нэгэндээ үлгэр дууриал болж байвч хүрээлэл бага байх шиг. Учир гэвээс би гэх Монгол орны алс зүүн хязгаарт ургасан нэгэн навч зүс ижил, зүг ойр, зорилго нэгт “Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо”-гэх миний төлөө бидний төлөө байгуулагдсан байгууллагыг дөнгөж саяхан тархиндаа шинээр кодлон оруулсандаа гайхасхийв. Нэр нь хүртэл халуун дулаан, ойр дотно байдлыг илэрхийлэх энэ байгууллагыг урьд сонсоогүй ажээ. Өөрийнхөө төлөө, дүүгийнхээ төлөө, өнө хойчийнхоо төлөө би юу хийх ёстой вэ? хэмээн эргэцүүлвээс яахын аргагүй жижигхэн ч гэсэн гэрлээр орчин тойрноо гийгүүлж, бидний төлөө гараа нийлүүлсэн хүмүүстэй нэгдэн, өөр олон олон гэрэлтэй гарыг нийлүүлж, хүрээллийг тэлэх нь, миний үүрэг ажээ.

Удахгүй, удахгүй л би өсч томорно, үр жимсээ дэлгэнэ. Дорнын гэх Зүүн Хойд Ази дэлхийн гүүр, эдийн засаг, хөгжлийн уурхай, тусламжийн гар, аз жаргалын хаалга болон гэрэлтэнэ. Тэр гэрлийг болбоос зургаан үзэсгэлэнт модны навч, нахиа бүр гартаа атгаж, дэлхий дахиныг гийгүүлнэ.

Монгол орны зүүн хязгаарт ургасан навч би зүрх, тархи хоёрынхоо цохилтыг чагнан мутарлаж, талын нар шингэх үест жаргаав.

The Association of Northeast Asia Regional Governments



Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбоо

The Association of Northeast Asia Regional Governments

Хаяг. Кёнсанбүг муж, Пухан хот, Намгү Жигугну 394(Жигугдун 601) Пухан Техно парк 3 давхарт

Утас. +82-54-223-2384 **Факс.** +82-54-223-2309 **E-mail** near@neargov.org **Website** www.neargov.org